



ГОВЬСУМБЭР АЙМАГ
СУМБЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 08

Сүмбэр сум

Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй
зээл олгох салбар чиглэлийг батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.3.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сумын хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох салбар, чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Зээл олгох салбар чиглэлийг мөрдөж ажиллахыг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах хорооны бүрэлдэхүүн, хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийн дарга, гишүүд, сумын Засаг дарга Т.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
зэлийт 6 дугаар хуралдааны 2022
оны 03 дугаар сарын 17-ний
өдрийн 02 тоот тогторлын
хавсралт



Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох
салбар чиглэлийн жагсаалт

1. Барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр:

-Стандартын шаардлага хангасан бетон зуурмагын үйлдвэр, түүний дагасан бетон
хийц

- Барилгын дүүргэгч материалын үйлдвэрлэл

- Барилгын материалын түүхий эд үйлдвэрлэл

2. Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:

-Өвлийн хүлэмж байгуулах

-Түүхий эдийн боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх

- Гахай, тахианы фермэрийн аж ахуй байгуулах

3. Хоёрдогч түүхий эд ангилан ялгаж боловсруулах

4. Зочид буудал, аялал жуулчлалын бааз байгуулах